



# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрүүл мэндийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2021/114/СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.dornogovi.audit.mn](http://www.dornogovi.audit.mn)  
Дорноговь аймаг  
2021 он

Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий  
Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn  
Аудитын менежер: У.Оюунтүлхүүр  
Утас: 70523020 Цахим хаяг: Oyuntulkhuur.u@audit.gov.mn  
Аудитор: Л.Равдандорж  
Цахим хаяг: Ravdandorjl@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	12
3. Аудитын тайлан.....	14
3.1. Ерөнхий зүйл.....	14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт .....	15
3.4. Материаллаг байдал .....	15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	16
3.7. Шилэн дансны мэдээлэл .....	17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
3.9. Аудитын илрүүлэлт.....	17
Залруулсан алдаа.....	178
Аудитын зөвлөмж.....	18
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	18
4. Менежментийн захидал.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	20

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт



### ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.08.25 № 1-6/251

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА  
Г.ЭНХЦЭЦЭГ ТАНАА

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрүүл мэндийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрүүл мэндийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Бусад мэдээлэл

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

440020477

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>120,536,555.13</u></b>	<b><u>282,220,579.57</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	00.00	711,972.29
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	00.00	711,972.29
3351	Байгууллагаас авах авлага	00.00	711,972.29
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	120,536,555.13	281,508,607.28
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	68,025,583.42	228,812,596.13
35110	Тусгай зориулалттай материал	64,627,589.52	69,244,763.20
35130	Эм боох материал	3,397,993.90	159,567,832.93
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	52,510,971.71	52,696,011.15
35410	Бичиг хэргийн материал	10,744,900.00	5,718,712.00
35420	Аж ахуйн материал	33,808,695.44	33,482,222.44
35430	Сэлбэг хэрэгсэл	60,000.00	887,990.00
35440	Түлш, шатах тослох материал	6,527,006.27	10,374,634.71
35450	Барилгын засварын материал	1,370,370.00	448,850.00
35470	Бусад хангамжийн материал	00.00	1,783,602.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>908,040,737.55</u></b>	<b><u>870,008,394.32</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	908,040,737.55	870,008,394.32
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	882,696,737.55	844,664,394.32
39201	Барилга, байгууламж, орон сууц	760,924,793.58	762,507,593.58
39202	Хуримтлагдсан элэгдэл	-15,424,713.48	-30,870,530.96
39203	Авто-тээврийн хэрэгсэл	140,471,297.00	140,471,297.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-62,771,297.00	-71,171,297.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	136,487,345.89	141,738,775.06
39206	Хуримтлагдсан элэгдэл	-97,652,161.18	-113,368,431.60
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	50,928,342.99	50,541,642.99
39208	Хуримтлагдсан элэгдэл	-30,675,036.67	-35,201,821.13
39214	Бусад үндсэн хөрөнгө	690,300.00	690,300.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-666,633.58	-673,133.62
39217	Ном	384,500.00	00.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	25,344,000.00	25,344,000.00
39301	Программ хангамж	785,000.00	785,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-785,000.00	-785,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	25,344,000.00	25,344,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,028,577,292.68</u></b>	<b><u>1,152,228,973.89</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>430,704.97</u></b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	00.00	430,704.97
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	00.00	430,704.97
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	430,704.97
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,028,577,292.68</u></b>	<b><u>1,151,798,268.92</u></b>

Эрүүл мэндийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,028,577,292.68	1,151,798,268.92
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	831,604,364.82	831,604,364.82
51101	Өмч: - төрийн	831,604,364.82	831,604,364.82
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	21,481,163.56	144,702,139.80
51210	Өмнөх үеийн үр дүн	21,481,163.56	21,481,163.56
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	123,220,976.24
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	175,491,764.30	175,491,764.30
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,028,577,292.68</u></b>	<b><u>1,152,228,973.89</u></b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,621,296,213.84</b>	<b>2,746,150,206.02</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>340,759,803.84</b>	<b>435,266,466.40</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	256,759,803.84	435,266,466.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	256,759,803.84	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	256,759,803.84	00.00
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	84,000,000.00	00.00
122001	Хандив тусламж /дотоод/	84,000,000.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1280536410.00</b>	<b>2310883739.62</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,153,249,500.00	1,495,960,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,153,249,500.00	1,495,960,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	127,286,910.00	814,923,239.62
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	14,613,470.00	79,817,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,977,100.00	42,186,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	33,947,400.00	241,847,160.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	65,748,940.00	451,072,579.62
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,495,319,188.28</b>	<b>2,622,415,278.69</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,495,319,188.28</b>	<b>2,622,415,278.69</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	842,809,871.60	2,025,259,638.28
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	339,974,036.10	588,552,086.27
210101	Үндсэн цалин	264,533,140.95	258,258,183.52
210102	Нэмэгдэл	33,605,032.35	263,605,417.82
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,607,344.00	29,953,512.89
210104	Урамшуулал	14,228,518.80	36,734,972.04
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	42,385,157.82	53,839,107.08
210201	Тэтгэврийн даатгал	30,281,669.72	37,865,242.07

Эрүүл мэндийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210202	Тэтгэмжийн даатгал	3,876,082.05	3,993,203.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,775,573.00	3,195,634.99
210204	Ажилгүйдлийн даатгал	681,091.00	799,068.58
210205	Эрүүл мэндийн даатгал	4,770,742.05	7,985,957.87
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>45,143,889.32</b>	<b>37,762,978.62</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,977,056.32	2,407,178.42
210302	Түлш, халаалт	25,688,441.00	29,969,848.20
210303	Цэвэр, бохир ус	14,478,392.00	5,385,952.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>20,880,426.23</b>	<b>70,279,529.28</b>
210401	Бичиг хэрэг	3,509,990.00	19,250,635.00
210402	Тээвэр, шатахуун	13,128,654.23	30,825,691.28
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,391,885.00	1,667,373.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	926,498.00	928,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,849.00	17,607,730.00
210408	Бараа материал акталсны зардал	422,550.00	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>195,714,664.32</b>	<b>704,008,818.89</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	195,714,664.32	683,902,818.89
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	20,106,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,368,378.00</b>	<b>279,484,839.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	150,398,621.00
210602	Тавилга	00.00	124,511,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	90,000.00	00.00
210604	Урсгал засвар	2,278,378.00	4,575,218.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>18,514,800.00</b>	<b>59,780,783.00</b>
210702	Дотоод албан томилолт	18,514,800.00	59,780,783.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>116,051,621.13</b>	<b>131,058,014.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	105,434,178.00	120,798,478.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,024,000.00	864,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	983,584.00	1,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	145,033.00	156,754.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	37,800.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,395,026.13	8,115,390.00
210807	Газрын төлбөр	32,000.00	79,392.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>61,776,898.68</b>	<b>100,493,482.14</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,366,487.00	53,027,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,137,475.00	803,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	44,272,936.68	46,662,482.14
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>652,509,316.68</b>	<b>597,155,640.41</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>623,893,369.00</b>	<b>545,002,407.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	334,841,707.00	205,080,007.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	288,451,662.00	336,162,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	3,760,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>09.00</b>	<b>00.00</b>

Эрүүл мэндийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	09.00	00.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	28,615,938.68	52,153,233.41
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,615,938.68	52,153,233.41
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>125,977,025.56</b>	<b>123,734,927.33</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	00.00	513,951.09
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	513,951.09
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	00.00	-513,951.09
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>125,977,025.56</b>	<b>123,220,976.24</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,280,536,410.00</b>	<b>2,310,883,739.62</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,280,536,410.00</b>	<b>2,310,883,739.62</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,153,249,500.00	1,495,960,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,153,249,500.00	1,495,960,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	127,286,910.00	814,923,239.62
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	14,613,470.00	79,817,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,977,100.00	42,186,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	33,947,400.00	241,847,160.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	65,748,940.00	451,072,579.62
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,269,854,910.00</b>	<b>2,301,355,149.62</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,269,854,910.00</b>	<b>2,301,355,149.62</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>617,345,593.32</b>	<b>1,667,359,509.21</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	338,347,752.35	592,213,611.67
210101	Үндсэн цалин	243,321,700.00	262,094,693.60
210102	Нэмэгдэл	45,561,510.35	264,065,167.82
210103	Унаа хоолны хөнгөлөлт	26,080,000.00	30,189,703.21
210104	Урамшуулал	23,384,542.00	35,864,047.04
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	40,882,171.52	53,829,100.00
210201	Тэтгэврийн даатгал	28,787,629.47	37,879,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,661,900.00	3,987,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,929,500.00	3,189,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	732,400.00	797,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,770,742.05	7,974,700.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	40,399,537.32	37,762,978.62
210301	Гэрэл, цахилгаан	4,977,056.32	2,407,178.42

Эрүүл мэндийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210302	Тулш, халаалт	25,590,936.00	29,969,848.20
210303	Цэвэр, бохир ус	9,831,545.00	5,385,952.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>24,256,800.00</b>	<b>47,962,930.72</b>
210401	Бичиг хэрэг	4,413,600.00	10,112,724.00
210402	Тээвэр, шатахуун	14,856,244.00	32,236,938.72
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,399,585.00	1,367,893.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,249,990.00	999,524.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,337,381.00	3,245,851.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>3,300,000.00</b>	<b>446,178,499.20</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,500,000.00	403,283,499.20
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	42,895,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>10,252,600.00</b>	<b>274,623,027.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	44,000.00	184,109,999.00
210602	Тавилга	00.00	82,600,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	6,708,600.00	2,966,600.00
210604	Урсгал засвар	3,500,000.00	4,946,428.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>18,478,800.00</b>	<b>70,020,783.00</b>
210702	Дотоод албан томилолт	18,478,800.00	70,020,783.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>123,975,874.13</b>	<b>85,465,396.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	113,731,001.00	74,083,860.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,024,000.00	864,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	983,584.00	1,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	145,033.00	156,754.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	37,800.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,022,456.13	9,237,390.00
210807	Газрын төлбөр	32,000.00	79,392.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>17,452,058.00</b>	<b>59,303,183.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,259,473.00	57,112,425.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,192,585.00	2,190,758.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>652,509,316.68</b>	<b>633,995,640.41</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>623,893,369.00</b>	<b>581,842,407.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	334,841,707.00	205,080,007.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	288,451,662.00	336,162,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	40,600,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>09.00</b>	<b>00.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	09.00	00.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>28,615,938.68</b>	<b>52,153,233.41</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,615,938.68	52,153,233.41
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>10,681,500.00</b>	<b>9,528,590.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>10,681,500.00</b>	<b>9,528,590.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>10,681,500.00</b>	<b>9,528,590.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>10,681,500.00</b>	<b>9,528,590.00</b>

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,681,500.00	9,528,590.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-10,681,500.00</u></b>	<b><u>-9,528,590.00</u></b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	00.00	00.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан** /Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	831,604,364.82	1,937,989.00	-73,606,661.65	759,935,692.17
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>831,604,364.82</b>	<b>1,937,989.00</b>	<b>-73,606,661.65</b>	759,935,692.17
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-23,858,347.01	-23,858,347.01
C08	<b>2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>831,604,364.82</b>	<b>175,491,764.30</b>	<b>21,481,163.56</b>	1,028,577,292.68
D01	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>831,604,364.82</b>	<b>175,491,764.30</b>	<b>21,481,163.56</b>	1,028,577,292.68
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>831,604,364.82</b>	<b>175,491,764.30</b>	<b>21,481,163.56</b>	1,028,577,292.68
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	123,220,976.24	123,220,976.24
D09	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>831,604,364.82</b>	<b>175,491,764.30</b>	<b>144,702,139.80</b>	1,151,798,268.92

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Хэтрэлт, хэмнэлт	Хувь
		Баглагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,495,960,500.00	1,443,814,933.82	52,145,566.2	96.5
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,495,960,500.00	1,443,814,933.82	52,145,566.2	96.5
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	902,965,700.00	901,972,526.82	993,173.2	99.9
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	414,034,500.00	414,034,500.00	0.0	100.0
210101	Үндсэн цалин	261,363,500.00	262,094,693.60	-731,193.6	100.3
210102	Нэмэгдэл	78,816,500.00	85,886,056.15	-7,069,556.2	109.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,650,000.00	30,189,703.21	4,460,296.8	87.1
210104	Урамшуулал	39,204,500.00	35,864,047.04	3,340,453.0	91.5
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	53,829,100.00	53,829,100.00	0.0	100.0
210201	Тэтгэврийн даатгал	37,879,700.00	37,879,700.00	0.0	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	3,987,300.00	3,987,300.00	0.0	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,189,900.00	3,189,900.00	0.0	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	797,500.00	797,500.00	0.0	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	7,974,700.00	7,974,700.00	0.0	100.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	37,763,700.00	37,762,978.62	721.4	100.0
210301	Гэрэл, цахилгаан	2,346,100.00	2,407,178.42	-61,078.4	102.6
210302	Түлш, халаалт	30,079,200.00	29,969,848.20	109,351.8	99.6
210303	Цэвэр, бохир ус	5,338,400.00	5,385,952.00	-47,552.0	100.9
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	23,642,000.00	23,642,000.00	0.0	100.0
210401	Бичиг хэрэг	3,995,200.00	3,995,199.00	1.0	100.0
210402	Тээвэр, шатахуун	15,215,700.00	15,216,467.00	-767.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,367,500.00	1,367,893.00	-393.0	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.00	999,524.00	476.0	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,063,600.00	2,062,917.00	683.0	100.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	278,940,000.00	278,939,765.20	234.8	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	276,440,000.00	276,444,765.20	-4,765.2	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,500,000.00	2,495,000.00	5,000.0	99.8
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	15,708,600.00	15,707,984.00	616.0	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,000,000.00	8,985,790.00	14,210.0	99.8
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,708,600.00	2,708,600.00	0.0	100.0
210604	Урсгал засвар	4,000,000.00	4,013,594.00	-13,594.0	100.3
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	6,695,500.00	6,372,200.00	323,300.0	95.2
210702	Дотоод албан томилолт	6,695,500.00	6,372,200.00	323,300.0	95.2

Эрүүл мэндийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	13,046,800.00	12,380,816.00	665,984.0	94.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,000,000.00	999,280.00	720.0	99.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	864,000.00	0.0	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,000,000.00	1,000,000.00	0.0	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	156,800.00	156,754.00	46.0	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00	0.0	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,900,000.00	9,237,390.00	662,610.0	93.3
210807	Газрын төлбөр	82,000.00	79,392.00	2,608.0	96.8
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	59305500.00	59303183.00	2,317.0	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	57,112,900.00	57,112,425.00	475.0	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,192,600.00	2,190,758.00	1,842.0	99.9
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	592994800.00	541842407.00	51,152,393.0	91.4
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	592,994,800.00	541,842,407.00	51,152,393.0	91.4
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	256,232,400.00	205,080,007.00	51,152,393.0	80.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	336,162,400.00	336,162,400.00	0.0	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	600,000.00	0.0	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,495,960,500.00	1,443,814,933.82	52,145,566.2	96.5
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,495,960,500.00	1,443,814,933.82	52,145,566.2	96.5
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,495,960,500.00	1,443,814,933.82	52,145,566.2	96.5

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>814,915,572.39</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>814,915,572.39</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	774,915,572.39
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	178,179,111.67
210102	Нэмэгдэл	178,179,111.67
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	24,320,930.72
210401	Бичиг хэрэг	6,117,525.00
210402	Тээвэр, шатахуун	17,020,471.72
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,182,934.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	167,238,734.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	126,838,734.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	40,400,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	268,443,633.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	183,069,999.00

Эрүүл мэндийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210602	Тавилга	82,600,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	258,000.00
210604	Урсгал засвар	2,515,634.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>63,648,583.00</b>
210702	Дотоод албан томилолт	63,648,583.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>73,084,580.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	73,084,580.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>40000000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>40,000,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	40,000,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>814915572.39</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>814,915,572.39</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	79,817,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	42,186,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	241,847,160.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	451,064,912.39

### 3.Аудитын тайлан

#### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Г.Энхцэцэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, батлагдсан төсвийг зохих хууль журмын дагуу зарцуулах талаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 14-өөс 2021 оны 01 дугаар сарын 19-ний хооронд Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Равдандорж хариуцаж хэрэгжүүлэв.

Эрүүл мэндийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 64 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Эрүүл мэндийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргаас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;
- Улсын хэмжээний үйлчилгээтэй болон гадаадын хөрөнгө оруулалттайгаас бусад эрүүл мэндийн байгууллага байгуулах, түүнд тусгай зөвшөөрөл олгох эсэх асуудлаар санал, дүгнэлт гаргаж, тухайн шатны Засаг даргад танилцуулах;
- Эмнэлгийн орыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хязгаарт багтаан зохицуулах;
- Харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавих;
- Харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн статистик мэдээлэл, эрүүл мэндийн байгууллагын тайлан, мэдээ, мэдээллийг нэгтгэн холбогдох байгууллагад өгөх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль;
- Төрийн аудитын тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;

- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”;
- Засгийн газрын 2020 оны 163 дугаар тогтоол “Төрийн албаны цалингийн нэгдсэн систем нэвтрүүлэх тухай”;

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Эрүүл мэндийн газар нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгөөс сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлын 1,152,229.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 11,522.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Эрүүл мэндийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 22,276.1 мянган төгрөгөөр буюу 2.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	712.0	712.0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	120,536.6	281,508.6	160,972.1
Үндсэн хөрөнгө	908,040.7	870,008.4	-38,032.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,028,577.3</b>	<b>1,152,229.0</b>	<b>123,651.7</b>
Өр төлбөр	0	430.7	430.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,028,577.3	1,151,798.3	123,221.0
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,028,577.3</b>	<b>1,152,229.0</b>	<b>123,651.7</b>

Авлага дансны үлдэгдэл 712.0 мянган төгрөг болж өссөн нь татварын албанаас хөгжлийн бэрхшээлтэй иргэний татвар чөлөөлөгдсөн мөн нийгмийн даатгалын тайлант оны шимтгэлийн илүү төлөлтөөс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 281,508.6 мянган төгрөг болж 160,972.1 мянган төгрөгөөр өссөн нь Ковид-19 цар тахлын үеийн болон бэлэн байдлыг хангах нөөц бүрдүүлсэн нь шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 870,008.4 мянган төгрөг болж 38,032.3 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй байсан номын фондыг эргэлтийн хөрөнгөнд шилжүүлсэн болон элэгдлийн зардлаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 430.7 мянган төгрөг болж өссөн нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний татварын хөнгөлөлтөөс үүссэн нийгмийн даатгалын шимтгэлийн зөрүү үүссэн нь шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл мянган төгрөг болж 123,221.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн ашигтай гарсан нь шалтгаалжээ.

Эрүүл мэндийн газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 2,746.150.2 мянган төгрөг, өмнөх оноос 1,124,854.0 мянган төгрөгөөр буюу 69.4 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй орлого, нэмэлт санхүүжилтийн орлого, урсгал үйл ажиллагааны орлого байна. Энэ нь Ковид-19 цар тахлын үеийн зардал болон Ковид-19 цар тахлын бэлэн байдлыг хангах зорилгоор Эрүүл мэндийн яам, аймгийн Онцгой комисс, АЗДТГ зэрэг газруудаас ирсэн санхүүжилт байна.

Нийт зардал өмнөх оноос 1,127,096.1 мянган төгрөгөөр буюу 74.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөдөлмөрийн хөлс, нормативт, эд хогшил, урсгал засвар, томилолтын зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд гэх мэт ... зардлууд байна. Энэ нь тайлант онд гарсан томоохон үйл ажиллагаа болох байна. Жишээ нь: Ковид-19 цар тахлын үеийн болон бэлэн байдлыг хангуулах ажил, 50 ортой төрөх эмнэлэг, 100 ортой эмнэлэг ашиглалтад орохтой холбогдсон зардлууд шалтгаалсан байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 1,495,960.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,495,960.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,495,960.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,495,960.5 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,495,960.5 мянган төгрөгийн санхүүжилт ирснээс урсгал үйл ажиллагаанд 1,443,814.9 мянган төгрөгийг зарцуулж 52,145.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,443,814.9 мянган төгрөг буюу 96.5 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 79,817.5 мянган төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 42,186.0 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 241,847.2 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 451,072.6 мянган төгрөг, нийт 814,923.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс нэмэгдэл цалин хөлсний зардалд 178,179.1 мянга, хангамж, бараа материалын зардалд 24,320.% мянган төгрөг, нормативт зардалд 167,238.7 мянган төгрөг, эд хогшил худалдан авах зардалд 268,443.6 мянган төгрөг, томилолтын зардалд 63,648.6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 73,084.6 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 40,000.0 мянга, нийт 814,915.6 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 7.7 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 142 мэдээлэл, хугацаа болоогүй 3 мэдээлэл, хугацаа хоцроосон 9 мэдээлэл байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 735.9 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	735.9	1	735.9			
Нийт дүн							

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 58,774.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 53,705.6 мянган төгрөгийн алдааг залруулж, 5,069.0 мянган төгрөгийн 2 алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 албан шаардлага, алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Эрүүл мэндийн байгууллагуудад үнэ төлбөргүй хуваарилсан хөрөнгийн тооцоог нийлж баталгаажуулж ажиллаагүй нийт 38,743.5 мянган төгрөгөөр зөрүүлсэн тайлагнасан байсныг залруулсан.
2. Нийгмийн даатгалд илүү төлөлттэй боловч авлагаар тусгаагүй 281.3 мянган төгрөгийг залруулсан.
3. Үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй авсан бараа материалыг тодруулга тайлангийн дүнгээс 14,392.8 мянган төгрөгөөр зөрүүлэн байсныг залруулсан.
4. Аймгийн Засаг даргын А/324, А/432 дугаар захирамжийн үлдэгдэл 288.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн боловч тайлант оны зардлаар хүлээн зөвшөөрсөн байсныг залруулсан.

#### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилсан хөрөнгийн тооцоог НББ-ийн анхан шатны баримтаар хөтөлдөггүй тул эд хариуцагчийн тайлан мэдээг данс бүртгэлийн дүнтэй дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

#### **4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### *Хөрөнгийн данстай холбоотой асуудал*

- 1.1. Илрүүлэлт: Байгууллагын эд хөрөнгийн тооллогыг хуулийн хугацаанаас өмнө хийсэн, эд хариуцагчийн хөрөнгийг тоолоогүй, эрүүл мэндийн бусад байгууллагад шилжүүлсэн хөрөнгийн тоо, мэдээ зөрүүтэй байсан зэрэг алдаа гарсан.
- 1.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, хөрөнгө алдагдах, бодит зарцуулалтыг тооцож ажиллах боломжгүй нөхцөл байдал үүсэхээр байна.
- 1.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” 14 дүгээр зүйл 14.3-т “төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна” Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйл 14.2. Төрийн байгууллага, албан газар төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг нь өөрт олгогдсон эд хөрөнгийн талаар дараах эрх, үүрэгтэй:”1/ өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах; 2/ улсын төсвөөс олгосон хөрөнгийг Төсвийн тухай хуульд заасны дагуу зарцуулж, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.3-т “жинхэнэ хэрэгжилтийн” 5.1.4-т “үнэн зөв байх” гэж тус тус заасан байдаг тул цаашид

*төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, холбогдох НББ-ийг анхан шатны баримтаар баталгаажуулан тайлан мэдээнд тусгаж ажиллах. Эд хариуцагчийн 2020 оны жилийн эцсийн үлдэгдлийг тоолж баримтаар баталгаажуулан ирүүлэх.*

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<b>2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код:
<b>2021</b>			дга-2021/114/ста-тшз
Шалгагдсан байгууллагын нэр:	Эрүүл мэндийн газар		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Байгууллагын эд хөрөнгийн тооллогыг хуулийн хугацаанаас өмнө хийсэн, эд хариуцагчийн хөрөнгийг тоолоогүй, эрүүл мэндийн бусад байгууллагад шилжүүлсэн хөрөнгийн тоо, мэдээ зөрүүтэй байсан зэрэг алдаа гарсан	0.0	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Г.Энхцэцэг, Н.Түмэннаст
2	Томилолтын зардлаас цалин хөлс, бага үнэтэй түргэн элэгдэх бараа материалын зардлаас хоолны зардал гаргасан.	3,547.0	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Г.Энхцэцэг, Н.Түмэннаст
3	Засаг даргын захирамжаар ирсэн санхүүжилтийн үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүй зарцуулсан.	1522.0	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Г.Энхцэцэг, Н.Түмэннаст
4	Эрүүл мэндийн байгууллагуудад үнэ төлбөргүй хуваарилсан хөрөнгийн тооцоог нийлж баталгаажуулж ажиллаагүй.	38,743.5	Залруулсан	Дарга, нягтлан бодогч	Г.Энхцэцэг, Н.Түмэннаст
5	Нийгмийн даатгалд илүү төлөлттэй боловч авлагаар тусгаагүй.	281.3	Залруулсан	Дарга, нягтлан бодогч	Г.Энхцэцэг, Н.Түмэннаст
6	Үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй авсан бараа материалыг тодруулга тайлангийн дүнгээс зөрүүлэн.	14,392.8	Залруулсан	Дарга, нягтлан бодогч	Г.Энхцэцэг, Н.Түмэннаст
7	Аймгийн Засаг даргын А/324, А/432 дугаар захирамжийн үлдэгдлийг буцаан төвлөрүүлсэн боловч тайлант оны зардлаар хүлээн зөвшөөрсөн.	288.0	Залруулсан	Дарга, нягтлан бодогч	Г.Энхцэцэг, Н.Түмэннаст
8	Байгууллагын эд хөрөнгийн тооллогыг хуулийн хугацаанаас өмнө хийсэн, эд хариуцагчийн хөрөнгийг тоолоогүй, эрүүл мэндийн бусад байгууллагад шилжүүлсэн хөрөнгийн тоо, мэдээ зөрүүтэй байсан зэрэг алдаа гарсан	0.0	Залруулсан	Дарга, нягтлан бодогч	Г.Энхцэцэг, Н.Түмэннаст
<b>ДҮН</b>		<b>58,774.6</b>			